

“Хvмvвнд төр эрхэм, Төрд хvн эрдэнэ”

Хvн ам, орон сууцны тооллого - 2010

2008 онд батлагдсан “Хvн ам, орон сууцны тооллогын тухай” хуулийн дагуу Монгол улс иргэдээ 10 дахь удаагаа 11 дvгээр сарын 11-17-ны өдрvвдэд тоолох гэж байгаа билээ. Монгол Улс анх 1918 онд хvн амаа тоолж 647 000 иргэдтэй гэсэн тоо гарч байсан бол 2000 онд 2 373 000 иргэдтэй болж, хvн ам нь 3,7 дахин өссөн байна. 1962 онд Монгол Улсын сая дахь иргэн, 1988 онд 2 сая дахь иргэн маань мэндэлсэн байна.

Сvвлийн 10 жилийн хугацаанд хvн ам зvй, эдийн засаг, нийгмийн байдалд гарсан оорчлолт, шалтгаан, нохцлийг судлах, ирээдvйн хvн ам зvй, эдийн засаг, нийгмийн хөгжлийг толовлох, бодлого, хотолборийг боловсруулах, эрдэм шинжилгээний ажил, судалгаанд шаардлагатай статистикийн тулгуур мэдээлэл, бүрдvвлэх зорилгоор энэ удаагийн хvн ам, орон сууцны тооллого явагдах гэж байна. Ингэснээр хаана шинээр сургууль, эмнэлэг барих вэ, засаг захиргааны хуваарилалтад оорчлолт орох уу, манай улсын хvн ам хэзээ гурван саяд хvрэх вэ, ирээдvйд тэтгэвэрт гарах ахмадуудад зориулж ямар бодлого боловсруулж эхлэх вэ? зэрэг нийгмийн олно тулгамдсан олон асуудлын хариултыг тодорхой болгох юм.

“Хvн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуульд “Үндэсний статистикийн хорооноос нийтэд ашиглуулах зорилгоор албан ёсоор боловсруулан нэгтгэснээс бусад хэлбэрээр хувь хvний холбогдолтой тооллогын мэдээллийг бусдад ашиглуулах, задруулахыг хориглоно” гэж заасан байх учир Таны аюулгvй байдалд ямар нэгэн саад, хохирол учирахгvй болно.

Энэ жилийн улсын тооллого нь урьд жилvвдэд болж байсан тооллогуудаас бие даасан хуулийн хvрээнд явагдаж байгаа, гадаадад оршин суугаа иргэдээ интернэтээр тоолох гэж байгаагаараа онцлогтой.

183 хоногоос дээш хугацаагаар гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэнийг интернетээр тоолох юм. Хилийн чанадад байгаа монгол иргэд www.toollogo2010.mn цахим хаягаар хандаж тооллогондоо хамрагдана.

Хvн ам, орон сууцны тооллого - 2010

Written by Administrator

Tuesday, 26 October 2010 06:44 -

Тооллого Монголын цагаар 2010 оны 11 дvгээр сарын 11-ний 00.00 цагт эхэлж, 17-ны одрийн 00.00 дуусах бoгoод Монгол улсын иргэн бvр регистрын дугаараараа бvртгvвлж, мэдээлэлээ оруулна. Дэлгэрэнгvй мэдээллийг дээрх вэб хуудаснаас авч болохоос гадна ЭСЯ-ны Хоёрдугаар нарийн бичгийн дарга Д.Уянгатай 087531135/6/ дугаарын утсаар холбогдон авч болно.

Монгол Улсын иргэн бvр энэхvв тооллогонд идэвхтэй оролцох vврэгтэй бoгoод vвгээрээ улс эх орныхоо хогжил, дэвшилд хувь нэмэр оруулж байгаа хэрэг юм. 2010 оны тооллогонд хамрагдсанаар иргэний шинэчилсэн бvртгэлд хамрагдаж чадах бoгoод торийн хувь хишиг хvртэх хууль ёсны баталгаа нь болно.

Иргэн Таныг Монгол Улсын хvн ам, орон сууцны тооллогонд идэвхитэй хамрагдаж, иргэний vвргээ биелvвлэхийг уриалж байна.
Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа ЭСЯ
Стокгольм хот